

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.01.10

Даланзадгад сум

Нэг: Удирдлага зохион байгуулалтын талаар

ҮАГ-ын харьяа Өмнөговь аймгийн Аудитын газар нь 2016 оны эрхэмлэх зорилтоо хууль эрх зүйн шинэ орчинд нийцүүлэн “Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлон Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэхүү зорилтын хүрээнд 2016 онд санхүүгийн ба гүйцэтгэл болон нийцлийн аудитыг нэгдсэн удирдамжийн дагуу бүтээгдэхүүн ажил үйлчилгээний дэд төлөвлөгөөг 5 бүлэг 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулан батлаж аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажиллаа.

Тус аудитын газарт 2016 онд 207,1 сая төгрөгийн төсөв батлагдаж, 207,0 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 203,6 сая төгрөг зарцуулан ажиллаа. Тайлант онд 11 үндсэн орон тоо батлагдаж аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, гүйцэтгэлийн аудитын аудитор шинжээч 4, санхүүгийн аудитын аудитор шинжээч 4, жолооч гэсэн орон тоогоор ажиллаж байна.

2016 оны байдлаар 4 гүйцэтгэлийн аудит, 10 нийцлийн аудит, 307 санхүүгийн аудит хийж 186 012,8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 105 335,0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 30,4 сая төгрөгийн төлбөрийн акт, 17 728,9 сая төгрөгийн албан шаардлага, 146 заалт бүхий зөвлөмж өглөө. Орон нутгийн төсөвт 67,9 сая төгрөгийг төвлөрүүлж, төлбөрийн акт барагдуулалт 62.8 хувь, албан шаардлагын хэрэгжилт 59.6 хувь, зөвлөмжийн хэрэгжилтийг 99,3 хувиар хангуулан ажиллалаа.

Хоёр: Санхүүгийн аудитын талаар

Үндэсний аудитын газрын харьяа Өмнөговь аймгийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын дагуу шинээр батлагдсан бодлого, арга зүйг баримтлан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем /СТАУС/ программыг 2015 оны санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглаж, амжилттай нэвтрүүлж ажиллаа.

2015 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлэн өнжөөх 10 байгууллага, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан 90, түүвэрт хамрагдах байгууллага 142, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 14, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 15, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 1, хувийн аудит гэрээгээр 35 байгууллага буюу нийт 307 байгууллага хамрагдаж аудитын газар 262 байгууллага буюу 85,3 хувь, гэрээгээр 35 байгууллага буюу 11,4 хувийг тус тус гүйцэтгэж үлдсэн 3,3 хувь буюу 10 байгууллагад итгэл үзүүлж өнжөөсөн байна.

2015 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар:

- Зөрчилгүй санал дүгнэлт 134 байгууллага
- Хязгаарлалттай санал дүгнэлт 16 байгууллага
- Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 1 байгууллага нийт 151 байгууллагад дүгнэлт өгч ажилласан байна.


Үүнээс аймгийн Аудитын газар 79 хувь буюу 118 байгууллагад, “Их монгол Хөлөг” аудитын компани гэрээгээр 21 хувь буюу 33 байгууллагын санхүүгийн тайланг тус тус баталгаажуулжээ.

Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан жагсаалтанд багтсан нууцын зэрэгт хамаарах Тагнуулын газарт ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар, аймгийн Аудитын газарт “Мэдээлэл аудит” ХХК санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн ба Газар хөдлөлтийг бүртгэх станцын бүтэцэд өөрчлөлт орж бие даасан санхүүгийн тайлан гаргаагүй, орон нутгийн өмчит “Таван толгой” ХК-ын санхүүгийн тайлан нь Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан “Их Монгол Хөлөг” аудитаар аудит хийгдээгүй зэргээс нийт 4 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар нийт 161,352,7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 87,876,9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж санхүү, төсвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 72,355,8 сая төгрөгийн зөрчилд 120 менежментийн захидал хүргүүлж, аудитаар илэрсэн алдаа, дутагдал, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх арилгуулах талаар нийт алдааны 11 хувь буюу 1,104,5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичиж, төсвийн зарчмыг зөрчсөн 17 төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, төсвийн хөрөнгийн зориулалтыг зөрчиж зүй бусаар зарцуулсан, хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг арилгахаар 15,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож ажилласан байна. Тэргүүлэх аудиторын тушаалаар, акт, албан шаардлага, зөвлөмжийг баталгаажуулан ажиллаа.


Тайлант сар 13,6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, актын барагдуулалт 85,2 хувь, албан шаардлагын хэрэгжилт 71,5 хувь, зөвлөмжийн хэрэгжилтийг 99,2 хувь хангуулан ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүнг графикаар харуулбал:



2016 онд санхүүгийн тайлангийн СТАУС программыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор хяналтын систем сайжирч аудитын чанар, үр өгөөж дээшлэн аудитын мөрөөр авсан албан шаардлага, зөвлөмж, зөрчлийн дүн өмнөх оноос өссөн байна.

Менежментийн захидлыг задлаж бүртгэлээр харуулвал:



Завсрын аудитын талаар

Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн нийлүүлэх дэд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Номгон, Ноён, Гурвантэс, Сэврэй сумдын төсөвт байгууллагууд болон ОНӨААТҮГазар, ИХШГӨБГ, Шүүх, БОЭТ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Татварын хэлтэс, аймгийн Музей, Прокурорын газарт тус тус завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар акт, албан шаардлага тогтоогоогүй бөгөөд 5235,1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж аудитын явцад 4652,8 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг асуудлын бүртгэлээр баталгаажуулан аудитад хамрагдсан байгууллагуудад хүргүүлж 2016 оны жилийн эцсийн аудитаар хэрэгжилтийг тооцож ажиллахаар тогтов.

Үндэсний аудитын газрын харьяа Өмнөговь аймгийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын дагуу шинээр батлагдсан бодлого, арга зүйг баримтлан 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлэн өнжөөх 33 байгууллага, түүвэрт хамрагдах байгууллага 32, төсөл сан 3, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан 76, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 15, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 1, хувийн аудит гэрээгээр 51 байгууллага буюу нийт 211 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх төлөвлөгөөг ТӨ-5 маягтаар боловсруулан 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ҮАГ-т хүргүүлсэн.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/72 тоот тушаалыг үндэслэн санхүүгийн тайланд аудит хийх

аудитор, шинжээч нарын хуваарийг тэргүүлэх аудиторын тушаалаар батлаж санхүүгийн тайлангийн аудитын стандарт, гарын авлага, арга зүйгээр бүрэн ханган СТАУС програмыг ашиглан төлөвлөлтийн үе шатны ажлуудыг дуусгаад байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит гуравдугаар хуралдаанд орон нутгийн төсвийн орлогыг 11450,0 сая төгрөг, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд 7158,4 сая төгрөгөөр зардал бууруулах саналыг оруулж эдийн засгийн хүндрэлтэй цаг үед төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулж ажиллахыг зөвлөлөө.

Ололттой тал:

Санхүүгийн аудитын үе шатны ажлуудыг батлагдсан журам гарын авлагын дагуу СТАУС програмд хугацаанд нь хийж гүйцэтгэж, чанарын хяналт сайжирснаар аудитын чанар үр өгөөж дээшилсэн.

Гурав: Гүйцэтгэлийн аудитын талаар

Гүйцэтгэл аудитаар 71 хүн өдрийг зарцуулан 242,6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Үүнд:

1. 2015 онд Улс орон нутгийн хөрөнгө оруулалт хэрэгжилт, үр дүн:

Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 1а/1703, 1а/1058, 1а/4232 албан тоотоор Хүрмэн, Номгон сумын сургуулийн их засвар, Даланзадгад сумын Эрдмийн гэгээ сургуулийн ариун цэврийн өрөөний засварын ажил нийт 240,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хуваарилагдсан байна. ТБОНӨХБАҮХАТХ-н 45 дугаар зүйлийн 45.1-д заасан дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж 2 төсөл арга хэмжээнд нээлттэй, 1 төсөл арга хэмжээнд харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийгдсэн байна. Тендерт шалгарсан компаниуд гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэж, ГХБХБГазар захиалагчийн хяналтыг хийж ажилласан байна. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн их засварын ажлыг холбогдох байгууллагууд капиталжуулан орлогод авсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтыг Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 9/4 тоот тогтоолоор 71 төсөл арга

хэмжээнд 30759,5 сая төгрөг батлагдсан байна. Худалдан авах ажиллагааны алба 18894,6 сая төгрөгийн 62 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас 33 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер, 32 арга хэмжээнд харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт зохион байгуулсан байна. Тендер шалгаруулалтанд үнэлгээний хороо гишүүдийн ирцийн бүрдлээс хамааран 8-30 хоногт багтаан үнэлгээг хийж, дүгнэлтийг захиалагчид хүргүүлэн ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасны дагуу бүх тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтаан гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтаас 26283,1 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэлд тусгаж, 964,0 сая төгрөгийг хөтөлбөр арга хэмжээнд зарцуулан зардлаар тусгасан байна.

2. Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын дүн:

Засгийн газрын 2010 оны 89 дүгээр тогтоолын дагуу Даланзадгад, Мандал-Овоо, Номгон сумдад нөөцийн бараа материалыг тоо хэмжээ, нэр төрлөөр бүрдүүлж, хадгалах, хамгаалах, сэлгэн шинэчлэх үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад үйл ажиллагаа явуулж байгаа 3 цэгт бараа материалын биет тооллого хийхэд улсын нөөцийн өвс, тэжээлийг зориулалтын дагуу зарцуулж, тооллогын явцад зөрчил илрээгүй. Аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй болно.

3. Монгол улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 9/4 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 105431,2 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 95009,3 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Төлөвлөсөн хэмжээнээс татварын орлого 1737,3 сая төгрөг буюу 2.8 хувиар, татварын бус орлого 7185.9 сая төгрөг буюу 58.9 хувиар тасарсан нь 1000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөх нөхцөлөөр олгосон санхүүжилтийн гэрээг сунгасан, уул уурхай компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон зэрэг нөлөөлжээ.

Төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлангаар 2015 онд батлагдсан төлөвлөгөөгөөр 89406,0 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 81508,2 сая төгрөг зарцуулж, 7897,7 сая төгрөг хэмнэсэн байна. Аудитын явцад зөрчил илрээгүй бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй.

Дөрөв: Нийцлийн аудитын талаар

Нийцлийн аудитаар дэд төлөвлөгөөний дагуу 4 аудитад 901 хүн өдөр зарцуулан сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 14,9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16381,8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 24 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт:

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12-р сарын 04-ны өдрийн 9/4 тоот тогтоолоор ОНХНСангаас олгох шилжүүлгийг 5649,2 сая төгрөг, сумдад олгох орлогын шилжүүлгийг 3389,5 сая төгрөг, аймгийн орлогын шилжүүлгийг 2259,6 сая төгрөгөөр баталсан байна. 2015 онд ОНХНСангаас олгох шилжүүлэг төлөвлөгөөгөөр 5649,2 сая төгрөг, гүйцэтгэлээр 4674,8 сая төгрөг байгаа нь батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 82.7 хувь буюу 974,4 сая төгрөгөөр дутуу санхүүжилт авсан байна. Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу сумдад 3389,5 сая төгрөг, аймагт 2259,7 сая төгрөг хуваарилагдсан байна.

Сумдууд иргэдээс гарсан саналыг тэргүүлэх ач холбогдолоор эрэмбэлж 191 төсөл арга хэмжээнд 4533,9 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 9/4 тоот тогтоолоор 26 төсөл, арга хэмжээнд 13402,6 сая төгрөгийг зарцуулахаар баталсан нь иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээ байсан нь Сангийн сайдын 43 дугаар тушаалын 4.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн. Мөн Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.4, Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан дагуу аймгийн ИТХ-ын 2 дугаар сарын 13-ны өдрийн 8/1 дүгээр тогтоол, 12 дугаар сарын 04-ний өдрийн 9/4 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон эх үүсвэрийг нэмэгдүүлэн баталсан байна. Нэмэгдүүлэн баталсан 8979,3 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ нь аймгийн ИТХ-н 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 6/4 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтанд батлагдсан, мөн өмнөх онуудад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журмын 4 зүйлийн 4.2, 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүдэд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж ажиллалаа. Мөн Сангийн сайдын 43 дугаар тушаал, ТБОНӨХБАҮХАТХууль, НАНБХАСЗАСЗУСТХуулийг хэрэгжүүлж ажиллаагүй Гурвантэс, Хүрмэн, Ханхонгор, Манлай, Мандаловоо, Даланзадгад,

Цогтовоо сумдын засаг дарга нарт албан шаардлага зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Аудитаар нийт 9558,9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 15,1 сая төгрөгийн төлбөрийн акт, 374,6 сая төгрөгийн зөвлөмж, 9169,2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

Аймгийн хэмжээнд 52 улсын төсвийн байгууллага, 127 орон нутгийн төсвийн байгууллага, 36 ОНӨААТҮГазар, 5 ТӨҮГазар, 2 хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани нийт 222 байгууллага цахим хуудсанд цэсээ байршуулсан байна. Өмнөх аудитаар нэгдсэн цахим хуудсанд 298 байгууллага байсан бол программд шинэчлэл хийгдсэнээр улсын бүртгэлийн гэрчилгээгүй 76 байгууллага хасагдсан байна.

Аудитаар 108 байгууллага хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн оруулж, 106 байгууллага хугацаа хожимдуулж мэдээлсэн, 6 байгууллага дутуу мэдээлсэн зөрчил илэрсэн. Өмнөх аудитаар 41 байгууллага хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээллээгүй байсан бол энэ онд 6 байгууллага болж өмнөх оноос 10.8 хувиар буурсан байна. Дутуу мэдээлсэн 6 байгууллагад зөвлөмж хүргэж ажиллалаа.

3. Сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийх аудит:

Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт 2015 оны 04 дүгээр сарын 20-28 хооронд нийцлийн аудит хийсэн. Сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийлгэхээр 4 нам буюу МАХН, МАН, АН, ХҮН, 1 бие даан нэр дэвшигч материалаа ирүүлсэн. Дээрх 4 нам, 1 бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрүүд Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тай нийцэхгүй байх магадлалтай байсан заалтуудыг аудитын явцад залруулга хийлгэхээр албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын дагуу МАХН, МАН, АН, ХҮН, бие даан нэр дэвшигч Д.Одбаяр сонгуулийн мөрийн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хариу албан тоотоор баталгаажуулан ирүүлсэн. Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд буюу 2016 оны 04 дүгээр сарын 28-нд Аймгийн сонгуулийн хороонд 4 нам, 1 бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг хүргүүлж ажиллалаа.

4. Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аудит:

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь заалтын дагуу Орон нутгийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг УАГ-с гаргасан аргачлалын дагуу хуулийн хугацаанд тогтоолоо. Зардлын дээд хэмжээг тогтооход албаны нууц байдлыг бүрэн хангаж хуулийн дагуу ажиллалаа.

1. Засгийн газрын тусгай сан үйл ажиллагааны үр дүн


Аудитын хүрээнд байгаль хамгаалах сан, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2016 оны үйл ажиллагаа хамрагдсан. Аудитаар байгаль хамгаалах санг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй, сангийн орлогыг журмын дагуу төлөвлөөгүй, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэнд Аймгийн ИТХ-д зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдад тэтгэлгийг журмын дагуу олгосон 4 сангийн хөрөнгийн үлдэгдлийг зориулалт бусаар зарцуулсан 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож улсын төсөвт төвлөрүүлж ажиллалаа.

2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

Аудитаар Усны тухай хуулийн 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийг хэрэгжүүлээгүй, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуулийн дагуу төлөвлөөгүй, ус, рашаан ашиглуулах дүгнэлтийг үндэслэлгүй гарсан зөрчлүүдэд 948,9 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нар хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллалаа.


ЗӨРЧИЛ
(САЯ ТӨГРӨГ)



3. Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл

Орон нутгийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардалд 250,2 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилагдсанаас 248,9 сая төгрөгийг зарцуулж 1,3 сая төгрөгийг хэммнэж ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулын хороодод батлагдсан төсвийг үр дүнтэй хуваариласан боловч зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх, зориулалт бусаар зарцуулах, НББ-ын анхан шатны баримтгүй зарцуулах зөрчлүүд илэрсэн байна.



Аудитаар илэрсэн 0,13 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 22,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шинэчлэгдсэн шилэн дансны цахим хуудсанд 224 байгууллагын мэдээлэл байршуулж, хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг 93,9 хувь, 6.4-т заасан мэдээллийг 83,9 хувьтай мэдээлж хуулийн хэрэгжилт 88,9 хувьтай байна.

НИЙТ ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ (сая төгрөг)



хүргүүлж ажиллалаа.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2980,8 сая төгрөгийн 681 захирамж, тушаал шийдвэр, 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 3543,7 сая төгрөгийн 139 гүйлгээг мэдээллээгүй байна.

Аудитаар 13820,3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 7,646,2 сая төгрөгийг аудитын явцад залруулж, 6174,1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчилд хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага

Тав: Аймгийн ИТХ-ын захиалгат болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

Аймгийн ИТХ-ын хүсэлтээр дэд төлөвлөгөөний дагуу 1 аудитад 864 хүн/цагийг зарцуулан гүйцэтгэж, 242,6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч ажиллалаа. Үүнд:

1.Орон нутгийн өмчит эрчим хүчний үйлдвэрийн газруудын 2015 оны үйл ажиллагаа /ҮАГ-ОНЗА/2016/01-ГА-ӨМАГ/

Ханбогд, Цогтцэций, Сэврэй, Гурвантэс сумдын ОНӨААТҮГ-уудын 2015 оны үйл ажиллагаанд аудит хийхэд Бизнес төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулж Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.2 -дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д ажилчдын албан тушаалын цалинг тус газрын захирал тогтоохоор заасныг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 242,6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитаар илэрсэн зөрчилд албан шаардлага, зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Зургаа: Дотоод ажлын талаар

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу аймгийн Аудитын газрын менежер нь аудитор, шинжээч нартай 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулан хагас, бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж ажиллалаа.

Аймгийн аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болох хөрөнгө орлогын мэдүүлэгийг гаргуулан авч, тайланг хуулийн хугацаанд авилгалтай тэмцэх газар хүргүүллээ. Үндэсний аудитын газрын нэгдсэн сүлжээгээр, хийгдэж буй аудитын явц, ажлын тайлангийн талаар тухай бүр онлайн хурал /12/, сургалтанд аудитор, шинжээч нар бүрэн хамрагдаж ирлээ.

МУЕА-ын 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн а/54 дугаар тушаалаар батлагдсан журам, маягт, заавар аргачлалын дагуу статистик мэдээг хагас, бүтэн жилээр гарган ҮАГ-т хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системийг хөгжүүлэх зарим ажлын төлөвлөгөөний дагуу “Аудитад мэдээллийн технологийг ашиглах, хөгжүүлэх зарим асуудал” сэдвийн дор Үндэсний аудитын газар, Нийслэлийн аудитын газар орон нутгийн аудитын газрын удирдлага, менежер, аудиторуудын дунд 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хэлэлцүүлэгт ахлах аудитор Ш.Наран, шинжээч Г.Шижирболд нар оролцлоо.

Мэдээлэл сурталчилгааг цахим хуудсаар 19, хэвлэн нийтэлсэн 13, радио телевизээр 1 нийт 20 мэдээ мэдээллийг нийтэд нээлттэй ил тод байдлаар түгээлээ. Мөн байгууллагын үйл ажиллагааны өдөр тутмын мэдээллийг тухай бүрт мэдээллэж, цахим мэдээллийг санг баяжуулж ажиллаа.

Засаг даргын захирамжаар “Ажнай талбай”-д хувиарлагдсан талбайдаа нэмж хайлаас мод 40, улиас мод 5 тарьж нийгмийн хариуцлагын хүрээнд бусад байгууллагыг манлайлан оролцсон.

ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу аудитын чанарын хяналт 2016 оны 08 сарын 21-24-ны өдрүүд тус аудитын газарт ажиллаж зөвөлгөө өгч, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүллээ.

Долоо: Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар

ҮАГ-ын харьяа Өмнөговь аймгийн аудитын газар нь 2015 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Зөрчилгүй санал дүгнэлт авч ажилласан байна.

Тус газар нь төсөв, санхүү, Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж стандартын дагуу хөтлөн явуулж төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллалаа.

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийллээ.

Тайлант онд 207,1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 207,0 сая төгрөгийн санхүүжилт авч цалин шимтгэлд 178,5 сая төгрөг, хангамжийн материалд 10,6 сая төгрөг, томилолт 10,3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, гэрээтийн цалинд 4,2 сая төгрөг, нийт 203,6 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлээр зарцуулж харилцах дансанд 3,4 сая төгрөгийг улсын төсвийн орлогод татан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд үүссэн өр авлагагүй ажилласан болно. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сар бүрийн 1-ны дотор ҮАГ-т хүргүүлэн ажиллалаа.

Шилэн дансны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын хэрэгжүүлэн тухай бүр 84, сар бүр 36, улирал бүр 4, хагас жил 4, бүтэн жил 10 мэдээлэл нийт 138 мэдээллийг хуулийн хугацаанд тус тус цахим хуудсаар бүрэн мэдээллэж, байгууллага дээрээ шилэн дансны мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллалаа.

ҮАГ-ын харьяа Өмнөговь аймгийн аудитын газрын 2017-2019 оны төсвийн хүрээний мэдэгдлийг өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, холбогдох тооцоо судалгаа, улс, орон нутагт мөрдөгдөж байгаа хууль эрхзүйн хүчин төгөлдөр актуудыг

үндэслэн байгууллагын удирдлагуудтай хамтран боловсруулж ҮАГ-т цаасаар болон цахимаар хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар тушаал, Өмнөговь аймгийн Засаг даргын 2016 оны а/345 дугаар захирамж, Өмнөговь аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2016 оны а/16, а/33 тоот тушаалыг тус тус үндэслэн Аудитын газрын эд хөрөнгийн улсын үзлэг тооллого, 2016 оны хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгэн ТӨХ-ны стандарт маягтаар бэлтгэж ҮАГ-т хүргүүлэн ажилласан.

Байгууллагын удирдлага нь батлагдсан төсвийн зардлын зүйл ангийн дагуу хөрөнгийг зарцуулсан эсэх, анхан шатны баримтын бүрдлийг тухай бүр бүрэн гүйцэд хангаж гүйлгээг хийж байгаа эсэхэд цаг тухайд нь хяналт тавин төсвийн зарцуулалтын мэдээг сар бүр хянаж гарын үсэг зуран баталгаажуулж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу дотоод хяналтыг тухай бүр хийж ажилласан.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон санхүүгийн бусад байгууллагуудаас шаардсан мэдээ тайланг тухай бүр хугацаанд нь үнэн зөв хүргүүлэн ажиллаж санхүү, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой сургалтанд тухай бүр хамрагдаж ажиллаа.

Найм: Дүгнэлт, санал

Үндэсний аудитын газрын харьяа Өмнөговь аймгийн аудитын газар нь 2016 оны төсвийн жилд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Гүйцэтгэл, Нийцлийн аудит хийхэд томилолт, шатахууны зардал аудитын хөтөлбөрт заагдсан хугацаанд ороогүй нь обектод хүрч ажиллахад хүндрэл учруулж байлаа.

Санхүүгийн аудит хийхэд СТАУС программ нь интернэтийн орчинд ажилладаг учраас сүлжээний хурднаас шалтгаалан ачаалалтай үед гацаж цаг хугацаа алдаж байлаа.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР